



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/09

Сүхбаатар сум

Сар шинийн баярт зориулсан "Цагаан сар-2019"  
үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1, аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/543 тоот захирамжаар батлагдсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад мөрдөх журам"-ын 3.1.5.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баярыг угтан "Цагаан сар-2019" үзэсгэлэн худалдааг аймгийн төв Сүхбаатар суманд 2018 оны 01 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Үзэсгэлэн худалдааны бэлтгэл хангах, зохион байгуулах ажлын хэсгийг дсорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнхжаргал

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал хазиуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Д.Лувсандагва

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Б.Энхбат

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ч.Жаргалсайхан

-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Г.Баатар  
Б.Мөнхтөр  
Д. Уранбилэг  
Б.Ундрах


О.Энэбиш

-Онцгой байдлын газрын дарга  
-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга  
-Сэлэнгийн долгио чуулгын дарга  
-Сэлэнгэ аймаг дахь Худалдаа аж  
үйлдвэрийн танхимын дарга  
/тохиролцсоноор/  
-Ажил олгогч эздийн холбооны  
тэргүүн /тохиролцсоноор/

3. Үзэсгэлэн худалдааны зардалд шаардагдах 2.160.053 /Хоёр сая нэг зуун  
жаран мянга тавин гурван/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг  
аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын  
үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

4. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж,  
чанарын өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга,  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга  
/А.Эрдэнзгэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ